

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
(2025 оны III улирлын байдлаар)

2025.09.15

Худалдан авах ажиллагааны газар

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
6	14	Төрийн хэмнэлтийн тухай 2022-04-29 Дугаар 2022.04.29	13.1.2. энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох; (13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах; 22.1.Энэ хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалтыг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)	Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор 253 төсөл арга хэмжээ буюу төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын 95.1 хувийг зохион байгуулсаны үр дүнд гүйцэтгэгч шалгарсан 212, тендер зарлаад амжилтгүй болсон 41 төсөл арга хэмжээ байна. Амжилтгүй болсон шалтгаан нь тендерт оролцогч огт байхгүй 3.8 тэрбум төгрөгийн төсөвтэй 17, шаардлага хангасан тендер ирээгүй улмаас амжилтгүй болсон 13.9 тэрбум төгрөгийн 24 төсөл арга хэмжээ байна. Мөн төлөвлөгөөнд тусгагдсан 17.0 тэрбум төгрөгийн 13 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй учир нь 8 төсөл арга хэмжээний зураг төсөв, 5 төсөл арга хэмжээний ажлын даалгавар ирээгүй. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 266 төсөл арга хэмжээнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу 2025 оны 05 дүгээр сарын 31-ний өдрийн дотор зохион байгуулж дууссан 212 төсөл арга	100%		

				хэмжээний гэрээг худалдан авах ажиллагааны цахим системд оруулсан. Худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон мөн зохион байгуулагдаагүй нийт 34.7 тэрбум төгрөгийн 54 төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.2-д заасны дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдож байна.			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
35	73	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-06-10 Дугаар 2025_04 ЁЗДБХ	1.1.1. 1/Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг ханган үр дүнд хяналт тавьж ажиллах;	Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолыг үндэслэн Аймгийн Засаг даргын 2023 оны А/845 захирамжаар Худалдан авах ажиллагааны газрыг 10 хүний бүтэц орон тоотойгоор байгуулж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Байгууллагын Ёс зүйн дэд хороог 2024.04.05-ний өдрийн А/07 тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ёс зүйн дэд хорооны гишүү ажлаас чөлөөлөгдсөн тул газрын даргын 2025.08.13-ний өдрийн А/12 тушаалаар Ёс зүйн дэд хороог шинэчлэн байгуулсан. Байгууллагын ёс зүйн дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган баталж дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. "Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сургалтыг албан хаагч нарт 2025.02.05-ний өдөр зохион байгуулсан. Сар бүрийн 3 дахь Даваа гарагт "Ёс зүйн зөвлөгөө өгөх өдөр" болгон хэвшсэн. АТГ-аас зохион байгуулсан "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх" сэдэвт сургалтад бүх албан хаагчыг хамруулсан.	100%		

				<p>Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагын талаарх сургалтыг 2 удаа зохион байгуулсан.</p> <p>Ажлын ачаалал, стрессийг хэрхэн даван туулах вэ сургалтыг хөгжөөнт тоглоом хэлбэрээр зохион байгуулсан.</p> <p>Шинээр ажилд орсон албан хаагч нарт байгууллагын ёс зүйн дүрэм болон Хөдөлмөрийн дотоод журмыг тухай бүр танилцуулж чиглүүлэх сургалтыг 2 удаа өгсөн.</p> <p>"Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал" хойд бүсийн зөвлөгөөнд албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p> <p>Албан хаагчдад "Ажлын байрны ёс зүй" гарын авлага боловсруулан тараасан.</p> <p>Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, болон албан хаагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэх талаар тусган хяналт тавьж ажиллаж байна.</p>			
	74		<p>1.1.3. 3/Монгол Улсын ЁС зүйн хорооны гишүүдийн, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх ЁС зүйн дэд хороодын гишүүдийн хараат бус, бие даасан зарчмаар ажиллах нөхцөл, баталгааг хууль тогтоомжийн хүрээнд</p>	<p>Байгууллагын ёс зүйн дэд хорооны гишүүдийг хараат бусаар ажиллах, үйл ажиллагаа явуулахад нь удирдлага болон хамт олны зүгээс идэвхитэй оролцон дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2025 оны 3-р улирлын байдлаар ажилтан, албан хаагчидын ёс зүй, хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх, хандлагаа өөрчлөх, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх чиглэлээр 5 удаагийн сургалт зохион байгуулж албан хаагчдынхаа ёс зүй талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэн ажиллаж байна.</p>	100%		

			бүрэн хангах зохицуулалт хийх.			
	75		1.3.1. 1/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн байгууллагын ЁС зүйн дэд хорооны гишүүдэд олгох урамшууллын асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэн үр дүнг тооцож ажиллах.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10.2-д заасны дагуу хороонд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглосон.Төрийн аудитын газраас урамшууллыг олгохгүй байх зөвлөмжийг өгсөн тул 2025 онд ёс зүйн дэд хороодын гишүүдэд урамшуулал олгоогүй байна. Байгууллагын ёс зүйн дэд хорооны явуулж буй үйл ажиллагаанд идэвхитэй оролцож удирдлага болон хамт олны зүгээс дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.	100%	
ЗГ-ын тогтоол						
30	41	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	2025 онд Орхон аймгийн төрийн 52 байгууллагуудаас 10.0 сая төгрөгөөс дээш өртөг бүхий 200 гаруй нэр төрлийн барааны жагсаалтыг авч цахим дэлгүүрт байршуулах саналыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт Аймгийн Засаг даргын 2025.06.06-ний өдрийн 01/2084 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 37.2.4-д заасны дагуу газар зүйн байрлалыг харгалзан Орхон аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрт сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд ашиглагдах байнгын хэрэгцээт бараа бүтээгдэхүүнийг байршуулах ажлын судалгааны шатыг эхлүүлээд байна. Орхон аймгийн төрийн өмчит 17 сургууль,	100%	

				<p>31 цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материалд 2024 оны жилийн эцсийн байдлаар 7.2 тэрбум төгрөг зарцуулж, дундажаар 62 нэр төрлийн барааг худалдан авсан байна. Үүнээс голлох хүнс болох мах, махан бүтээгдэхүүнд 3.7 тэрбум төгрөг, Сүү, сүүн бүтээгдэхүүнд 757 сая төгрөг, төмс хүнсний ногоонд 693.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Эдгээр гол хүнсний бүтээгдэхүүн нь ЦАХИМ ДЭЛГҮҮР-т байршсан хэдий ч Улаанбаатар хотоос орон нутаг худалдан авалт хийхэд тээвэрлэлт, хүргэлтийн нэмэгдэл зардлууд гарах учир хуульд зааснаар газар зүйн байрлалыг харгалзан үзэж Орхон аймагтаа бүсчилсэн хэлбэрээр цахим дэлгүүрт бараа бүтээгдэхүүнийг байршуулах ажлын бэлтгэл үе шатыг хийгээд байна. Үүнд:</p> <p>Төрийн Худалдан авах ажиллагааны газартай хамтран Орхон аймгийн 52 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, ААНБ-уудад 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр "Ерөнхий гэрээний арга"-ыг хэрхэн хэрэгжүүлэх, "ЦАХИМ ДЭЛГҮҮР"-т бараа бүтээгдэхүүнээ байршуулах ач холбогдол, анхаарах асуудлуудын талаарх сургалт хийсэн.</p> <p>2025 оны 08 дугаар сарын 28-ны өдөр Ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч, хоол зүйч нарт "Ерөнхий гэрээний арга"-ыг хэрхэн хэрэгжүүлэх, "Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсэнд ашиглагдах бараа материалыг ерөнхий гэрээний аргаар зохион байгуулж, цахим дэлгүүрээс худалдан авахад анхаарах асуудал", "Орхон аймгийн ЕБС, цэцэрлэгүүдэд ашиглагдаж буй хүнсний</p>			
--	--	--	--	---	--	--	--

				бүтээгдэхүүний судалгаа” зэрэг сэдвээр сургалт, танилцуулгыг хийж ажилласан. Сургалтад нийт 108 албан хаагчид хамрагдсан байна.			
39	58	Журам батлах тухай “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам” 2024-10-09 Дугаар 2024_120_1	2.. Энэ тогтоолын хавсралтаар баталсан журмыг (Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам) үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч, төвлөрүүлэн захирагч, төсвийн шууд захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагад тус тус үүрэг болгосугай. (3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга Э.Одбаяр, Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус даалгасугай)	2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 200.0 сая төгрөгийн “Төрийн цэргийн байгууллагын шаардлагатай цахим тоног төхөөрөмж худалдан авах” төсөл арга хэмжээг Төрийн нууцад хамааруулж Онцгой байдлын газарт шилжүүлэн худалдан авах ажиллагааг “Төрийн нууцад хамаарах худалдан авах ажиллагааг зохицуулах журам”-ын дагуу зохион байгууллаа. Дээрх худалдан авах ажиллагааг зохион байгуулснаас хойш 2025 оны 9 дүгээр сарын байдлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт хийгдээгүй бөгөөд төрийн нууцад хамаарах төсөл арга хэмжээ нэмэгдээгүй болно.	100%		

44	64	Жагсаалт батлах тухай 2024-12-25 Дугаар 2024_233	2. 2. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газар, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн дотор тус тус хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Биелэлтийг ХОХБТХ гаргана. Тайлбар: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэх ажлуудын жагсаалтыг уг тогтоолоор баталсан. Улсын төсвийн ажлуудын худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулдаг. Батлагдсан төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс гаргаж хүргүүлэх ёстой. Худалдан авах ажиллагааны газрын чиг үүрэгт хамаарахгүй тул уг тогтоолыг хяналтаас хасуулах саналтай байна.	-		
	65		3. 3.Худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасан дугаар төсөл. арга хэмжээний дугаар нэр хүчин чадал, байршил төслийн код ("УТ" код)-ыг	Аймгийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэхээр төлөвлөгдсөн. Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд 266 төсөл арга хэмжээний нэр хүчин чадал, байршил төслийн кодыг батлагдсан хэлбэрээр тусгаж тендер шалгаруулалтыг 100 хувь цахим системээр зохион байгуулж ажилласан. 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, давхардсан тоогоор нийт 317 тендерийн зарлал, тендерийн нээлт, үр дүн, тендер шалгарсан 212 төсөл арга хэмжээний	100%		

		<p>батлагдсан хэлбэрээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч, Төрийн худалдан авах ажиллагааны газарт тус тус даалгасугай.</p>	<p>гэрээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд тухай бүр оруулан ил тод мэдээлж ажилласан. Мөн Аймгийн ЗДТГ-ын www.erdenet.mn, Аймгийн ИТХ-ын itkh-orkhon.gov.mn, Орон нутгийн www.erdenetnews.mn, Худалдан авах ажиллагааны газрын khaag.erdenet.mn сайт мөн Худалдан авах ажиллагааны газрын Facebook пэйж хуудсаар худалдан авах ажиллагааны мэдээллийг иргэд олон нийтэд ил тод мэдээлэхээс гадна ХАА-ны анхны төлөвлөгөөг Хотын шуудан сонины 2025 оны 01-р сарын 28-ний өдрийн №200/200 дугаарт нийтлүүлж Орхон аймгийн иргэд, ААНБ-уудад мэдээлсэн.</p>			
66		<p>4. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлан шуурхай зохион байгуулж ажиллахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар, төсвийн ерөнхийлөн захирагч нар т даалгасугай.</p>	<p>Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ тусгагдсаны дагуу 253 буюу 95.1 хувийг хуулийн дагуу шуурхай зохион байгуулсны үр дүнд гүйцэтгэгч шалгарсан-212, тендер зарлаад амжилтгүй болсон-41 төсөл арга хэмжээ байна. Төсөл арга хэмжээний зураг төсөв, ажлын даалгавар ирээгүй шалтгаанаар 13 төсөл арга хэмжээ буюу нийт төсөл арга хэмжээний 4.9 хувийг зохион байгуулаагүй байна. Тендерт оролцогч компаниуд шаардлага хангахгүй, тендерт оролцогч байхгүй шалтгаанаар 17.7 тэрбум төгрөгийн 41 тендер амжилтгүй болоод байна. Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт гүйцэтгэгч шалгарсанаар 79.7 хувийн биелэлттэй байна. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шуурхай зохион байгуулсан.</p>	100%		

40	59	ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ ШИЛЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2024-11-13 Дугаар 2024_163	2. 2.Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программ хангамжийн лицензийг Ерөнхий гэрээгээр худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу нэгдсэн журмаар зохион байгуулахыг Монгол Улсын Шадар сайд Т.Доржхандад, холбогдох зардлыг төсвийн багцдаа тусган санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгосугай.	Байгууллагын албан хаагчдын ашиглаж буй 22 ширхэг ухаалаг төхөөрөмжид албан ёсны лицензтэй үйлдлийн систем программ хангамжийг суулган ашиглаж байна. 2025 онд баримт бичиг боловсруулахад шаардлагатай үндэсний Монгол бичгээр хөрвүүлэгч Кимо программыг албан ёсны лиценз эзэмшигч Болор софт ХХК-аас худалдан авч ашиглаж байна.	100%		
42	62	Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай 2024-12-18 Дугаар 2024_217	2. 2. Хүн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд танилт, нэвтрэлтийн системийг ашиглахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга нарт болон төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад тус тус үүрэг болгосугай.	Худалдан авах ажиллагааны газар нь 100 хувь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хүн хувь, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээ байхгүй тул хяналтаас хасуулах саналтай байна.	-		
62	91	Ажил, амралтын цагийн	1. 1.Үндэсний их баяр наадам, Ардын		100%		

	<p>зохицуулалтын тухай 2025-06-04 Дугаар 2025_279</p>	<p>хувьсгалын ойн баярын 2025 оны 07 дугаар сарын 12, 13-ны өдрүүд нь Бямба, Ням гарагт тохиож байгаатай холбогдуулан 2025 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амрааж, 2025 онд багтаан нөхөн ажиллуулах зохицуулалт хийхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай.</p>	<p>Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд “Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр долоодугаар сарын 10, 11, 12, 13, 14, 15; “ гэж тус тус зааж, эдгээр өдрүүдэд нийтээр амрахаар хуульчилсан. 2025 оны тухайд 7 дугаар сарын 12, 13-ны өдөр нь амралтын өдөр тохиосонтой холбогдуулан 16, 17-ны өдөр нийтээр амрах зохицуулалтыг Засгийн газраас хийсэнтэй холбогдуулан Худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Б/23 тоот тушаалаар ажилтан, албан хаагчдыг 2025 оны 07 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд нөхөн ажиллуулсан.</p>			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл						

90	134	<p>Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13</p>	<p>22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;(Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)</p>	<p>Аймгийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 125.3 тэрбум төгрөгийн 266 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор 253 төсөл арга хэмжээ буюу 95.1 хувийг шуурхай зохион байгуулсаны үр дүнд гүйцэтгэгч шалгарсан 212, тендер зарлаад амжилтгүй болсон 41 төсөл арга хэмжээ байна. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудаас 13 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулагдаагүй учир нь 8 төсөл арга хэмжээний зураг төсөв, 5 төсөл арга хэмжээний ажлын даалгавар ирээгүй. Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт гүйцэтгэгч шалгарсанаар 79.7 хувийн биелэлттэй байна. Худалдан авах ажиллагааны явц, үр дүнгийн талаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-нд тухай бүр, Аймгийн ЗДТГ-ын www.erdenet.mn, Аймгийн ИТХ-ын itkh-orkhon.gov.mn, Орон нутгийн www.erdenetnews.mn, Худалдан авах ажиллагааны газрын khaag.erdenet.mn сайт мөн Худалдан авах ажиллагааны газрын Facebook пэйж хуудсаар иргэд олон нийтэд ил тод мэдээлэхээс гадна Аймгийн Засаг даргын шуурхай зөвлөгөөн, Аймгийн ИТХ-ын зөвлөлийн хуралд мэдээлэл бэлтгэн танилцуулсан.</p> <p>Нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг энэ хүү биелэлтийг ХОХБТХ-ээс авна уу.</p>	100%		
----	-----	---	--	--	------	--	--

99	145	Засгийн газрын 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 31 дүгээр тэмдэглэл 2024-09-04 Дугаар 2024_31	31.9.6. 2/ Төрийн байгууллагын "gov.mn" нэгдсэн цахим хуудаст мэдээллийг байршуулах, тухай бүр шинэчлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт	Худалдан авах ажиллагааны газар 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр байгууллагын info@or.spa.gov.mn домэйн хаягийг нээлгэж АЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд байгууллагын танилцуулга мэдээ, мэдээллийг хүргүүлж Төрийн байгууллагын "gov.mn" сайтад хандах эрхийг нээлгэн Байгууллагын танилцуулга, сургалт сурталчилгаа, Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны зар мэдээ, цаг үеийн холбогдолтой 11 мэдээллийг нийтэлж тухай бүр шинэчлэн ажиллаж байна.	100%		
----	-----	--	---	--	------	--	--

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

Худалдан авах ажиллагааг хариуцсан
 ахлах мэргэжилтэн  Д.ЭРДЭНЭСҮХ
 Худалдан авах ажиллагааг хариуцсан
 Мэргэжилтэн  О.ЭНХБАЯР

НЭГТГЭСЭН:

Дотоод хяналт, шалгалт хариуцсан
 мэргэжилтэн  Б.БАТТӨР

ТАНИЛЦСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА  Д.ОЮУНБАЯР